

Эргэлдэж буй дугуйнууд

Тус бүр нь нэг буюу түүнээс олон сэтэрхийтэй 5 ширхэг тунгалаг биш дугуй өгөгджээ. Эдгээр дугуйнуудыг хурдан хугацаанд зөв зэрэгцүүлэх даалгаврыг биелүүл. Дугуй бүр дугаартай бөгөөд эргэлдэж эхлэхэд бүгд өгөгдсөн дугаарын дагуу байрласан байна. Дугуйнууд бүгд цагийн зүүний дагуу эргэх бөгөөд бүгд төд удалгүй 1 градус 2 градусын өнцгийг өнгөрөн эргэнэ (хэдийгээр зэрэг биш ч гэсэн).

Энэ бодлого нь бүхэл тооны бодлого өөрөөр хэлбэл дугуйнууд хэзээ ч 1.5 градус эсвэл 23.51234123 гэсэн өнцөгт байрлахгүй. Дугуйнуудын хурднаас хамааран агшин зуурт л 20-оос 25 градус руу эсвэл 30-аас 40 градус руу шилжинэ. Дугуй бүр секундэнд тодорхой бүхэл тоон градусаар ($0 \leq \text{хурд} \leq 180$) эргэнэ.

Дугуйн дахь сэтэрхий нь эхлэлийн өнцөг болон хэмжээ гэсэн хоёр бүхэл тоогоор илэрхийлэгдэнэ. Тестийн өгөгдөл дэх сэтэрхийнүүд нь хоорондоо дор хаяж нэг градусын зайтай байна.

Дугуйнууд эргэж эхлэх үед буюу 0 цагт бүх дугуйнууд дугаарын дагуу дарааллан байрласан байна. Дугуйнууд дээрхи сэтэрхийнүүд ямар цагт давхцахыг олох програм бич. Энэ үед гэрлийн туяа бүх дугуйнуудын зайгаар нэвт тусах боломжтой болох юм. Эргэлтийн аль ч үед энэ агшин тохиож болно.

ПРОГРАМЫН НЭР: spin

ОРОЛТЫН ФОРМАТ

5 мөр бүр нэг дугуйг илэрхийлнэ.

Мөрийн

- эхний бүхэл тоо нь дугуйн эргэлтийн хурд
- дараагийн тоо нь дугуйн дээрх сэтэрхийний тоо ($1 \leq W \leq 5$)
- Дараагийн W хос бүхэл тоо бүр сэтэрхийний эхлэлийн өнцөг болон хэмжээ.

ЖИШЭЭ ОРОЛТ (файл spin.in)

30 1 0 120

50 1 150 90

60 1 60 90

70 1 180 180

90 1 180 60

ГАРАЛТЫН ФОРМАТ

Нэг мөрөнд ганц бүхэл тоо байна. Энэ нь эхний удаа дугуйнуудын нүх зэрэгцэх үе, энэ үед гэрлийн туяа нэвт тусах боломжтой. Хэрвээ дугуйнууд хэзээ ч ингэж зэрэгцэхгүй бол 'none' (жижиг үсгээр хашилтгүйгээр) гэж хэвлэ.

ЖИШЭЭ ГАРАЛТ (файл spin.out)

9

Орчуулсан Б.Даваабаяр